



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/362

Эрдэнэт


Гамшгийн бэлэн байдлыг хангах сургалт
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.5/a/, 29.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1 дэх заалт, Монголын Улаан Загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.13 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд баг бүрт гамшгийн бэлэн байдлын талаарх иргэд, олон нийтийн мэдлэг хандлага дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах **ӨРХИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ** сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гал түймрийн аюул, үер, газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга, мал, амьтны халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлд зориулсан эрүүл мэндийн анхны тусламж чиглэлээр зохион байгуулах сургалтыг удирдамж, сургалтын хуваарь, хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шаардагдах 59770000/ Тавин есөн сая долоон зуун далан мянган/ төгрөгийг “Баг бүрд анхны тусламжийн нөхөрлөл байгуулах сургалтанд хамруулж дадлагажуулах” зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дүгээр сарын 28 ны өдрийн
4/36 захирамжийн хоёрдугаар хавсралт

**ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ
СУРГАЛТЫН ТӨСӨВ**

№	Үйл ажиллагаа	Хамрагдах хүний тоо	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Бүгд
1	Цайны зардал	370	4000	2 өдөр	2960000
2	Сургагчийн цүнх /анхны тусламжийн иж бүрдэл/		26000	360	9360000
3	Малгай		6000	360	2160000
4	Үзүүлэх сургалт		500 000	2 удаа	1000000
5	Холбооны зардал		41000	6	246000
6	Хантааз		26 000	360	9360000
7	Сайн дурын идэвхтний унааны зардал	324	6000	6 удаа	11664000
8	Сайн дурын идэвхтний гарын авлага	360	4000	4 багц	5760000
9	Ахлагч нарын урамшуулал	36	20 000	6	4320000
10	Сургагч багшийн урамшуулал	2	200 000	6 өдөр	2400000
11	Өрхүүдэд гарын авлага материал		2500	3600	9000000
12	Сургалтын үйл ажиллагааны баримтжуулалт		50000	2 удаа	100000
13	Бичиг хэргийн зардал/сурталчлагч нарт/		4000	360	1440000
	Нийт				59770000